



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/629

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Сургуулийн
профессор багшийн хөгжлийг
дэмжих хөтөлбөрийг батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.10 дахь хэсэг, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 7.4 дэх хэсэг, МУИС-ийн ректорын зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “МУИС-ийн Профессор багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр (2025-2030)”-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн ректорын 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/52 тоот тушаалаар батлагдсан “МУИС-ийн багшийн хөгжлийн хөтөлбөр (2019-2024)”-ийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тус хөтөлбөрийг холбогдох нэгжүүдэд сурталчлан, хэрэгжүүлэн ажиллахыг Багшийн хөгжил, суралцахуйг дэмжих төвийн эрхлэгч (С.Отгонцэцэг), Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газрын дарга (С.Булгантамир), бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирал (Б.Болд-Эрдэнэ, Ц.Амартайван, Н.Батнасан, Б.Амарсанаа, С.Мөнхбат, Ч.Сономдагва, Б.Ганбат, Ц.Пүрэвсүрэн, Д.Алтанхуяг, Б.Мядагмаа) нарт үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар)-т үүрэг болгосугай.

РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ

1425065289

Монгол Улсын Их Сургуулийн ректорын
2025 оны 1^д дугаар сарын 3^д-ны өдрийн
4/629 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ПРОФЕССОР БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР 2025-2030

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Дээд боловсролын байгууллагууд нь сургалт, судалгаа инновацын уялдааг хангах, багшийн мэргэжлийн хөгжлийг тасралтгүй дэмжих, боловсролын чанарыг хүний нөөцийн чадавхаар баталгаажуулах үүрэгтэй талаар “Боловсролын ерөнхий хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, “Багшийн хөгжлийн дэмжих тухай хууль”-д заасан байдаг. Энэхүү хөтөлбөрийн агуулга, үзэл санааг дээр дурдсан хуулиуд болон МУИС-ийн Стратеги төлөвлөгөө (2025-2030) зэрэг бодлогын баримт бичгийн үзэл баримтлалд тулгуурлан “Сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын журам”, “МУИС-ийн профессор багшийн албан тушаалын зэрэглэл ахиулах, ажлын гүйцэтгэлийг тооцох журам”, “Багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журам”-тай уялдуулан хэрэгжүүлнэ. Энэ нь багшийн гүйцэтгэлийг сургалт-судалгаа-нийгмийн үйлчилгээний гурвалсан чиглэлээр хөгжүүлэх, цахим шилжилт, олон улсын стандарттай нийцүүлэх үндэс болно.

1.2. МУИС-ийн Профессор багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр (2025-2030)-ийн зорилго нь сургалтын чанарыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, инновацыг дэмжих, багшийн ур чадварыг шат дараатай хөгжүүлэхэд оршино.

1.3. Тус хөтөлбөрийг МУИС-ийн багшийн хөгжил хариуцсан нэгж холбогдох нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.


ХОЁР. Нэр томьёо

2.1. *Багшийн сургалтын чадамж* гэж суралцагчид мэдлэг, чадвар, хандлагыг бүтээлчээр эзэмшүүлэх үр дүнтэй сургалтын арга зүйг хэрэглэх чадварыг;

2.2. *Багшийн судалгааны чадамж* гэж шинжлэх ухааны мэдлэг бүтээх, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтад хувь нэмэр оруулах чадварыг;

2.3. *Багшийн нийгмийн үйлчилгээний чадамж* гэж нийгэм, салбарын хөгжил, бодлого, соёл, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх чадварыг;

2.4. *Менторшип* гэж туршлагатай багшийн чиглүүлгээр хувь хүний болон мэргэжлийн чадварыг дэмжих зорилготой хөгжлийн хамтын ажиллагааг;



2.5. Сургалтын инновац гэж сургалтын зорилго, агуулга, арга зүй, технологи, үнэлгээнд шинэчлэл хийж, түүний үр нөлөө, чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн шинэ санаа, арга, шийдлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, түгээх үйл явцыг тус тус хэлнэ.

ГУРАВ. Хөтөлбөрийн зарчим болон зорилтууд

3.1. Үндсэн зарчмууд:

- 3.1.1. Багшийн хөгжил нь албан тушаалын зэрэглэлд тавих шаардлагын дагуу ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх үйл явц байна.
- 3.1.2. Суралцагчийн амжилтыг нэмэгдүүлэх ба хүртээмжтэй байдлыг сайжруулах үүднээс бүх суралцагчдад ээлтэй, оролцоог дэмжсэн сургалтыг нотолгоо, судалгаанд тулгуурласан арга зүйгээр явуулна.
- 3.1.3. Сургалт, үнэлгээ, судалгааны чиглэлийн үйл ажиллагаанд хиймэл оюуныг ёс зүйтэйгээр хэрэглэнэ.
- 3.1.4. Харилцан суралцах болон менторшип нь хөгжлийн гол арга хэлбэр байна.
- 3.1.5. Үр дүнг хэмжиж, шилдэг туршлагыг урамшуулах замаар тогтвортой байдлыг хангана.

3.2. Зорилтууд:

- 3.2.1. Нотолгоонд суурилсан, суралцагч төвтэй, хүртээмжтэй арга зүйг төлөвшүүлж, сургалтын чанарыг сайжруулна.
- 3.2.2. Шинэ технологи, хиймэл оюунд суурилсан сургалтыг хариуцлагатай, үр дүнтэй зохион байгуулах чадварыг дээшлүүлнэ.
- 3.2.3. Профессор багшийн судалгааны болон сургалтын манлайллыг дэмжиж, сургалтын инновацыг урамшуулна.
- 3.2.4. Албан тушаалын зэрэглэлд нийцсэн багшийн тасралтгүй хөгжлийн боломжийг бүрдүүлнэ.
- 3.2.5. Профессор багшийн хөгжлийн үйл ажиллагааг үнэлж, урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.

ДӨРӨВ. Хөтөлбөрийн төлөвлөлт

4.1. Хөтөлбөрийн хүрээ

МУИС-ийн профессор багш нь сургалт, судалгаа, нийгмийн үйлчилгээ гэсэн гурван чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн мэдлэг, ур чадвар, үнэт зүйл, ёс зүйг хослуулсан чадамжид суурилан ажиллана. Профессор багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр нь сургалт, судалгаа, нийгмийн үйлчилгээний суурь чадамжуудыг хөгжүүлэх, дэмжихэд чиглэнэ.

4.2. Профессор багшийн хөгжлийн шаталсан загвар


Шаталсан загвар нь профессор багшийн мэргэжлийн ур чадвар, сургалт, судалгаа, нийгмийн үйлчилгээний чадамжийг албан тушаалын зэрэглэлтэй уялдуулан системтэйгээр хөгжүүлэхэд чиглэсэн хэрэгсэл юм. Энэхүү загварыг

ашиглан профессор багш нь хөгжлийн чиглэл, хэрэгцээгээ тодорхойлох боломж бүрдэнэ.

Албан тушаал	Хөгжлийн чиглэл	Хөгжих хэлбэр
Дадлагажигч багш	- Заах арга зүйн үндэс - Сургалтын агуулга ба үнэлгээний суурь ойлголт - Хичээл төлөвлөх, суралцахуйн үр дүн тодорхойлох чадвар - Ёс зүй, байгууллагын соёлын суурь мэдлэг	- Заах арга зүйн сургалт - Менторшип хөтөлбөрт хамрагдах - Туршлага солилцох бүлэг - Мэргэжлийн хөгжлийн бусад сургалт, хөтөлбөрүүд
Багш	- Идэвхтэй сургалт ба үнэлгээний олон төрөл -Цахим сургалт боловсруулах, хэрэгжүүлэх - Сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын судалгаа хийх - Судалгааны арга зүй, өгүүлэл хэвлүүлэх - Хиймэл оюун ба өгөгдөлд суурилсан сургалт хөгжүүлэх	- Судалгааны арга зүй болон хиймэл оюуны хэрэглээний сургалт - Өгүүлэл хэвлүүлэхэд дэмжлэг өгөх хөтөлбөр - Сертификат олгох богино сургалтууд - Туршлага солилцох семинар
Ахлах багш	- Сургалтын хөтөлбөрийн удирдлага ба шинэчлэл -Хүртээмжтэй сургалт - Өгөгдлийн шинжилгээ - Төсөл хэрэгжүүлэх ба удирдах - Сургалтын инновацыг хэрэгжүүлэх - Нотолгоонд суурилсан хичээл сайжруулалт	- Төслийн менежментийн сургалт - Сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн хөтөлбөр үйлчилгээнд хамрагдах - Сургалтын хөтөлбөр шинэчлэлт
Дэд профессор	- Сургалтын судалгаа ба нотолгоонд суурилсан бодлого боловсруулах - Менторшип хөтөлбөр - Гадны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх - Сургалтын чанарын баталгаажуулалтын удирдлага	- Сургалтын нотолгоонд суурилсан сайжруулах судалгаа - Менторшип хөтөлбөр - Бодлогын судалгаанд оролцох - Салбар дундын судалгаа
Профессор	- Стратегийн манлайлал ба байгууллагын инновац - Инновацын экосистем бүрдүүлэх - Олон улсын хамтын ажиллагаа - Нийгмийн манлайлал - Академик нөлөөлөл	- Байгууллагын түвшний стратегийн манлайлал - Олон улсын судалгааны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх - Бодлого боловсруулахад оролцох - Нийгмийн манлайлал үзүүлэх үйлчилгээ

4.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн мөчлөг

МУИС-ийн Стратеги төлөвлөгөө 2025-2030-тай уялдуулан МУИС-ийн профессор багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг дараах хоёр шаттай хэрэгжүүлнэ.




Хэрэгжилтийн шат	Хугацаа	Чиглэл, үр дүн
Нэгдүгээр шат	2025-2026	Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах суурь сургалт, хөтөлбөрүүдийг багшийн хөгжил хариуцсан нэгж зохион байгуулж бүрэлдэхүүн/салбар сургууль, тэнхим нэгжүүд дэмжиж ажиллана. Залуу багшийн менторшип үйл ажиллагаа, сургалтын инновацыг дэмжих хөтөлбөр, хичээлийн агуулга, үнэлгээний шинжилгээ хийх гэх мэт сургалтын чанарт нөлөөлөх үйл ажиллагааг тогтмол хийх тэнхимийн соёл, дадлыг суулгана.
Хоёрдугаар шат	2027-2030	Багш нар өгөгдлийн шинжилгээний аргуудад үндэслэн сургалтын агуулга, арга зүйг тасралтгүй шинэчлэх тогтолцоог бүрдүүлж сургалт, судалгаа, нийгмийн үйлчилгээний чадамжийг сайжруулах үйл ажиллагааг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Профессор багшийн хөгжлийн бүртгэл, гүйцэтгэл, үр дүнгийн хяналтын нэгдсэн системийг хэрэгжүүлнэ.

4.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явц, жилийн төлөвлөлтийн мөчлөг

МУИС-ийн профессор багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт нь багшийн хөгжил хариуцсан нэгж, бүрэлдэхүүн сургууль, тэнхим болон багш нарын нягт хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжих үйл явц байна.

4.4.1. Багшийн хөгжил хариуцсан нэгж нь:

- 4.4.1.1. Профессор багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн дагуу багшийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад үндэслэн жил бүр төлөвлөгөө гаргана.
- 4.4.1.2. Шинэ арга зүй, технологийн чиг хандлагад нийцүүлэн сургалт үйлчилгээний удирдамж, агуулга бэлтгэх ажлыг удирдлагаар хангана.
- 4.4.1.3. Сургалт, үйл ажиллагааг танхим, цахим эсвэл хосолсон байдлаар зохион байгуулна.
- 4.4.1.4. Залуу, шинэ багшид зориулсан менторшип хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх системтэй үйл ажиллагааг зохион байгуулна.
- 4.4.1.5. Сургалт, үйлчилгээний дараах өгөгдөл (санал асуулга, үр дүн)-д дүн шинжилгээ хийж жилийн эцэст сургалт, үйлчилгээний дүн шинжилгээнд үндэслэн сайжруулалт хийнэ.
- 4.4.1.6. Тэнхим, бүрэлдэхүүн сургуулийн багшийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаа холбоотой ажиллана.
- 4.4.1.7. Сургалтын мэдээллийг бүртгэх, нэгтгэх, профессор багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийнэ.



4.4.2. Бүрэлдэхүүн/салбар сургууль нь:

- 4.4.2.1. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн сургалт, судалгаа, хүний нөөцийн онцлогт нийцүүлэн багшийн хөгжлийн зорилт, чиглэлийг тодорхойлж жилийн төлөвлөгөө (Хавсралт 1) гаргана. Төлөвлөгөөнд бүрэлдэхүүн/салбар сургуулийн хэмжээнд хийгдэх багшийн хөгжлийн үйл ажиллагааг тусгана.
- 4.4.2.2. Төлөвлөгөөний хэрэгжилтэд шаардлагатай санхүү, материал, хүний нөөцийн дэмжлэг, төсвийн хуваарилалтыг сургуулийн захиргааны зөвлөлийн шийдвэрээр баталгаажуулна.
- 4.4.2.3. Сургуулийн хэмжээнд төлөвлөсөн багшийн хөгжлийн ажлуудыг зохион байгуулж багш нарын оролцоог хангана.
- 4.4.2.4. Төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, оролцоог хянана. Жилийн эцэст сургуулийн багшийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг (Хавсралт 2) Багшийн хөгжил хариуцсан нэгжид хүргүүлнэ.
- 4.4.2.5. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн багшийн хөгжлийн үйл ажиллагааг тэнхим болон багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлнэ.
- 4.4.2.6. Сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр сургалтын шинэ арга зүй, сургалтын инновац, цахим болон хосолсон сургалтыг хэрэгжүүлэх орчныг бүрдүүлнэ.

4.4.3. Тэнхим нь:

- 4.4.3.1. Хичээлийн жилийн эхэнд багшийн хөгжлийн хэрэгцээ, сургалтын шаардлагыг үнэлж тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгана.
- 4.4.3.2. Шинээр томилогдсон залуу багш нарт ментор багш оноож, сургалт болон судалгааны чиглэлд дэмжлэг үзүүлнэ.
- 4.4.3.3. Тэнхимийн хурлаар багш нар сургалт, судалгааны арга зүйн сайн туршлагаа хуваалцах тогтолцоог хэвшүүлнэ.
- 4.4.3.4. Бүрэлдэхүүн/салбар сургуулийн төлөвлөгөөнд нийцүүлэн тэнхимийн хэмжээнд багшийн хөгжлийн сургалт, семинар, богино хугацааны модуль сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна. Багшийн хөгжлийн үйл ажиллагаанд шаардлагатай зардал, дэмжлэгийг хуваарилж, хэрэгжилтийг хангана.
- 4.4.3.5. Тэнхимийн багш нарын багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн өөрийн үнэлгээг нэгтгэж, тэнхимийн төлөвлөсөн ажлуудын хэрэгжилт, үр дүнг үнэлнэ.

4.4.4. Багш нь:

- 4.4.4.1. Багш хичээлийн жилийн эхэнд багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөөг (Хавсралт 3) гаргаж тэнхимд өгнө. Багш хувийн төлөвлөгөөнд сургалт, судалгаа, нийгмийн үйлчилгээний чадамжийг сайжруулах үйл ажиллагааг тусгана.



- 4.4.4.2. Профессор багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хийгдэх сургалт, үйлчилгээ, төсөл хөтөлбөрүүдэд өөрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн оролцоно.
- 4.4.4.3. Тэнхимийн багшийн хөгжлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож туршлага солилцоно.
- 4.4.4.4. Хичээлийн жилийн эцэст хувийн төлөвлөгөөний хэрэгжилтийн өөрийн үнэлгээг (Хавсралт 4) хийж, багшийн ажлын гүйцэтгэл, албан тушаалын зэрэглэл ахиулахад баримт болгон ашиглана. Хэрэгжилтийн үнэлгээг холбогдох баримтын хамт тэнхимд өгч багшийн хөгжлийн үйл ажиллагааны нэгтгэлд оруулна.

ТАВ. Хэрэгжилт, үр дүн ба үнэлгээ

5.1. Хөтөлбөрийн бүтэц

Уг хөтөлбөрийг сургалт, судалгаа, нийгмийн үйлчилгээний чадамжийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

5.1.1. Сургалтын чадамжийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Үйл ажиллагаа	Тайлбар	Хүлээгдэж буй үр дүн
Сургалтын хэлбэр, зохион байгуулалтыг шинэчлэх, сайжруулах үйл ажиллагаа	Багш суралцагчийн оролцоог идэвхжүүлэх, идэвхтэй сургалтын арга хэрэглэх чадварт суралцана. Сургалтын хэлбэр, үнэлгээний аргыг шинэлэг, үр дүнтэй болгоно.	Багш хичээлийн зохион байгуулалтыг эргэн харж, шинэ аргуудыг туршиж хэрэгжүүлсэн байна. Суралцагчийн суралцах идэвх, сургалтын чанар нэмэгдэнэ.
Сургалтын чанарыг дээшлүүлэх, хичээлийн хөтөлбөрийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа	Хичээлийн суралцахуйн үр дүн, агуулга, үнэлгээний дүн шинжилгээ тогтмол хийх, багаар хэлэлцэх, хичээлийн үнэлгээ, агуулгыг сайжруулах соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагаанууд орно.	Сургалтын чанар тогтмол дээшилнэ. Суралцагчийн сэтгэл ханамж нэмэгдэнэ. Багш нарын үнэлгээ арга барил сайжирна.
Сургалтын инновацыг дэмжих хөтөлбөр	Багш сургалтын арга зүйд дэвшилтэт технологи, шинэлэг арга барилыг турших, хөгжүүлэх боломжийг олгоно. Багшийн бүтээлч байдал, сургалтын чанарыг сайжруулахад шаардлагатай мэргэжлийн ур чадвар олгох нөхцөлийг бүрдүүлнэ.	Сургалтын чанар сайжирна. Хичээлийн үр нөлөө нэмэгдэнэ. Багшийн сургалтын үйл ажиллагаанд зарцуулах цаг багасна.

Шинэ багшийг чиглүүлэх үйл ажиллагаа	Их сургуулийн дүрэм журам, бодлого, зохион байгуулалт, ажлын гүйцэтгэл, сургалтын технологи, ёс зүйн чиг баримжаа олгох сургалтын үйл ажиллагаа орно.	Багшийн үндсэн үүрэг, хариуцлагыг үр дүнтэй гүйцэтгэх чадамж төлөвшинө. Ажиллах хүчний залгамж халаа сайжирч, байгууллагын үнэт зүйл, мэдлэг, туршлага тогтвортой дамждаг болно.
Хиймэл оюун ашиглан багшлахуй	Хичээл сургалтын үйл ажиллагаанд хиймэл оюуныг ёс зүйтэй хэрэглэж сурна.	Багш хиймэл оюунт хэрэгслүүдийг хариуцлагатай, ёс зүйтэй ашиглах чадварт суралцана.
Цахим боловсруулах хичээл үйл ажиллагаа	Цахим сургалт зохион байгуулах үр чадварыг хөгжүүлэх зорилгоор цахим хичээл боловсруулах загвар, ажиллагаа, цахим сургалтын системийн хэрэглээг эзэмшүүлэх сургалтуудыг зохион байгуулна.	Багш нар бие даан цахим хичээл боловсруулах чадвартай болно. Цахим сургалтын чанар, хүртээмж, хандалт нэмэгдэнэ. Сургалтын олон талт хэлбэрийг суралцагчдад санал болгоно.
Залуу багшийн менторшип хөтөлбөр	Ахмад туршлагатай багш нар мэдлэг, арга зүй, хандлагын түвшинд залуу багшид дэмжлэг үзүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд уулзалт, чиглүүлэх зөвлөгөө, хичээл ажиглалт, туршлага хуваалцах арга хэмжээнүүдийг зохион байгуулна.	Хөдөлмөрийн сэтгэл ханамж нэмэгдэнэ. Шинэ багш нарын ажлын байрны стресс багасна. Багшийн хамтын ажиллагаа сайжирч багийн соёл төлөвшинө.


5.1.2. Судалгааны чадамжийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Үйл ажиллагаа	Тайлбар	Хүлээгдэж буй үр дүн
Судалгааны арга зүй, өгөгдлийн боловсруулалт	Судалгааны үндсэн болон дэвшилтэт арга зүй, өгөгдөл цуглуулах болон боловсруулах чадварыг хөгжүүлнэ. Багш өгөгдлийн үнэн зөв байдал, найдвартай байдлыг хангах, судалгааны чадамжийг цогц байдлаар дээшлүүлэх сургалт, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Судалгааны асуудал тодорхойлох, тохирох арга зүй сонгон хэрэгжүүлэх чадвар сайжирна. Судалгааны өгүүллийн тоо нэмэгдэнэ.

Судалгааны ёс зүйн ойлголт	Судалгааны үйл явцад мөрдөх ёс зүйн үндсэн зарчим, өгөгдлийн нууцлал, судлаачийн хариуцлага, ёс зүйн зөвшөөрөл авах, бүтээлийн хулгай, зохиогчийн зохисгүй үйлдэл зэргийн талаар зөв ойлголттой болно.	Судалгааны ёс зүйн мэдлэгтэй багш нарын тоо нэмэгдэнэ. Ёс зүйн зөрчил багасна. 9024080427
Төслийн санал бичих, төсөл хэрэгжүүлэх, удирдах	Судалгааны төслийн санал бичих бүтэц, шаардлага, логик хүрээ, төсөв боловсруулах, төслийн хэрэгжилт, тайлан, удирдлагын арга зүйд суралцана. Олон улсын санхүүжилтийн боломж, төслийн баг бүрдүүлэлт, эрсдэлийн менежментийн мэдлэг, чадвар эзэмшинэ.	Судалгааны чадамжийг сайжруулна. Төслийн санал бичих багш нарыг тоог нэмэгдүүлнэ. Амжилттай хэрэгжүүлэх төслийн тоо нэмэгдэнэ.
Судалгааны өгүүлэл, өгөгдлийн шинжилгээнд хиймэл оюуныг хэрэглэх	Багш, судлаачдын судалгааны бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор судалгааны өгүүлэл бичихэд хиймэл оюуныг ёс зүйтэй, үр дүнтэй ашиглах чадамж олгох сургалт зохион байгуулна. Судалгааны тоон болон чанарын өгөгдлийн шинжилгээ хийх, тайлбарлахад хиймэл оюунт хэрэгслүүд болон машин сургалтыг ашиглах практик воркшоп зохион байгуулна.	Судалгааны өгөгдөлд хиймэл оюунд суурилсан шинжилгээ хийх чадвар нэмэгдэнэ. Судалгааны өгүүллийн тоо нэмэгдэнэ.

5.1.3. Нийгмийн үйлчилгээний чадамжийн хүрээнд болон бусад хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Үйл ажиллагаа	Тайлбар	Хүлээгдэж буй үр дүн
Нийгмийн манлайллыг дэмжих үйл ажиллагаа	Орон нутаг, алслагдсан бүсийн багш нарт зориулсан сургалт зохион байгуулна. Олон нийтэд зориулсан нээлттэй лекц, цахим хичээл, танин мэдэхүйн контент бэлтгэн гаргах, соёлын өв, түүх, үндэсний	МУИС нийгэмд чиглэсэн мэдлэгийн төв, шинжлэх ухаанч, соён гэгээрүүлэгч байгууллага байж нийгэмд эергээр нөлөөлнө.



	дархлааг дэмжихэд чиглэсэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хийнэ.	
Сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал	Стресс менежмент, ажлын ачааллын зохицуулалт, ажлаас шалтгаалсан ядаргааг бууруулах менежмент, ажил амьдралын зохицол, багш нарын ажлын байран дахь тухтай байдлыг хангах үйлчилгээ, үйл ажиллагааг зохион байгуулна.	Багш нарын сэтгэл ханамж дээшилнэ. Стрессийн түвшин буурч, ажлын ачааллыг оновчтой удирдах чадвар сайжирна. Ажлын бүтээмж нэмэгдэнэ.
Олон улсын хамтын ажиллагаа	Олон улсын байгууллагуудтай хамтарсан сургалт, хөтөлбөр хэрэгжүүлнэ. Гадаадын их сургуулиудтай түншлэл бий болгож, багшийн хөгжлийн сайн туршлагыг авч хэрэгжүүлнэ.	Багш нарын гадаад хамтын ажиллагаа нэмэгдэж, олон улсад нэр хүнд дээшилнэ.

5.2. Үнэлгээ

- 5.2.1. Багш жил бүр багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн өөрийн үнэлгээ хийнэ.
- 5.2.2. Тэнхим нь багшийн хөгжлийн хувийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг нэгтгэж, дүн шинжилгээ хийнэ.
- 5.2.3. Бүрэлдэхүүн/салбар сургууль хүний нөөцийн бодлогын хүрээнд профессор багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээ хийж, тайланг багшийн хөгжил хариуцсан нэгжид ирүүлнэ.
- 5.2.4. Профессор багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн нэгдсэн үнэлгээг Багшийн хөгжил хариуцсан нэгж хийж гүйцэтгэнэ.
- 5.2.5. МУИС-ийн профессор багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн нэгтгэлийг үнэлэхэд Киркпатрикийн 4 түвшний үнэлгээний загварыг ашиглана.

Түвшин	Үзүүлэлт	Өгөгдөл цуглуулах арга
Түвшин 1: Хариу үйлдэл	Хөтөлбөрт оролцсон багшийн сэтгэл ханамж	Сургалтын дараах санал асуулга, фокус бүлгийн ярилцлага
Түвшин 2: Суралцсан үр дүн	Шинэ мэдлэг, үр чадвар	Сургалтын өмнөх болон дараах үнэлгээ, багшийн өөрийн үнэлгээ

Түвшин 3: Хэрэглээ	Ажилдаа нэвтрүүлсэн байдал	Танхимын ажиглалт, сургалтын өгөгдлийн шинжилгээний дүн, судалгааны үйл ажиллагаанд ашигласан байдал ATA13089 9104399 9024080427
Түвшин 4: Нөлөө	Байгууллагын түвшний нөлөө	Суралцагчийн судалгаа, судалгааны тоо, эрэмбийн түлхүүр үзүүлэлт

5.3. Сайжруулалт

- 5.3.1. МУИС-ийн багшийн хөгжил хариуцсан нэгж жил бүр профессор багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэж, тайлан гаргаж сайжруулалтын төлөвлөгөө боловсруулна.
- 5.3.2. Үнэлгээнд сургалт, хөтөлбөрийн чанар, оролцогчдын сэтгэл ханамж, үр нөлөөг харгалзана.
- 5.3.3. Багш нарын хамтын ажиллагааг дэмжиж, хичээл сургалтын агуулгыг сайжруулах, шинэлэг арга зүйг нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.
- 5.3.4. Багшийн хөгжлийн чиглэлээр олон улсын байгууллага, гадаадын их сургуулиудтай хамтран ажиллаж, туршлага, арга зүй, стандартыг үе шаттайгаар нутагшуулах ажлын хэрэгжүүлнэ.
- 5.3.5. Багшийн хөгжлийн үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээлэл, өгөгдлийн шинжилгээг сайжруулж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

5.4. Тогтвортой байдал ба дэмжлэг

- 5.4.1. МУИС-ийн удирдлага багшийн хөгжлийн дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллаж бүрэлдэхүүн/салбар сургуулийн оролцоог нэмэгдүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5.4.2. Албан тушаалын зэрэглэл ахиулах шалгуурт сургалтын шинжилгээ, инновацын үйл ажиллагааг тусгаж, чанарыг сайжруулахад сэдэлжүүлнэ.
- 5.4.3. Багшийн ажлын гүйцэтгэл, сургалтын чанарт суурилсан урамшууллын тогтолцоог үе шаттайгаар боловсронгуй болгож, багшийн хөгжлийн үйл ажиллагаанд тогтвортой оролцох идэвхийг нэмэгдүүлнэ.
- 5.4.4. Олон улсын байгууллагуудтай хамтарсан сургалтын технологийн чиглэлээрх семинарыг өргөн хүрээнд зохион байгуулна.
- 5.4.5. Багшийн хөгжлийн үйл ажиллагааны бүртгэл, удирдлагын мэдээллийн системийг бий болгож, багшийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлт, бүртгэл, гэрчилгээ, тайлан гаргах боломжоор хангаснаар багшийн хөгжлийн үйл ажиллагааг системтэй, ил тод, үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс болно.




БҮРЭЛДЭХҮҮН/САЛБАР СУРГУУЛИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Он: 202.. – 202.. оны хичээлийн жил
Бүрэлдэхүүн/салбар сургууль: Бүрэлдэхүүн/салбар сургууль

Онцгойлох

№	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүлээгдэх үр дүн	Хариуцах хүн	Үзүүлэлт
1					
2					
3					
4					
5					

Боловсруулсан: /захирлын туслах/
Баталсан: /бүрэлдэхүүн сургуулийн захирал/



БҮРЭЛДЭХҮҮН/САЛБАР СУРГУУЛИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Он: 202.. – 202.. оны хичээлийн жил


Бүрэлдэхүүн/салбар сургууль: бүрэлдэхүүн/салбар сургууль

Он/сар/өдөр

№	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Үзүүлэлт	Хэрэгжилт	Гүйцэтгэл
1					
2					
3					
4					
5					

Боловсруулсан: /захирлын туслах/
Баталсан: /бүрэлдэхүүн сургуулийн захирал/

БАГШИЙН ХӨГЖЛИЙН ХУВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
202... – 202... оны хичээлийн жил




Он/сэр/өдөр

Багшийн нэр:	Албан тушаалын зэрэглэл:
Тэнхим:	Бүрэлдэхүүн сургууль:

№	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хүлээгдэх үр дүн
1				
2				
3				
4				
5				

Боловсруулсан: /багш/
Хянасан: /тэнхимийн эрхлэгч/

БАГШИЙН ХӨГЖЛИЙН ХУВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ
202... – 202... оны хичээлийн жил



Он/ср/өдөр

Багшийн нэр:	Албан тушаалын зэрэглэл:
Тэнхим:	Бүрэлдэхүүн сургууль:

№	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүлээгдэх үр дүн	Хэрэгжилт	Гүйцэтгэл
1					
2					
3					
4					
5					

Боловсруулсан: /багш/
Хянасан: /тэнхимийн эрхлэгч/